

まんがでわかる



Монгол хэл


モンゴル語版

# 介護業の安全衛生


Комикоор танилцах

Асаргааны ажлын аюулгүй байдал, эрүүл ахуй






Өнөөдөр асаргааны ажлын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сурцгаая.



Асаргаа нь өндөр настанг асарч сувилдаг ажил тул аюулгүй байдал, эрүүл ахуй онцгой шаардлагатай шүү.




Тийм шүү



Асаргааны ажилчид ерөнхийдөө ямар зүйлийг анхаарч ажилладаг юм болоо?


Мэдэх юм саан



Эхлээд хөдөлмөрийн осол үүсэх нөхцөл байдлын талаар харцгаая.

За, ойлголоо

Хөдөлмөрийн ослын гол шалтгаан нь ийм байдалтай байна.



### Хөдөлмөрийн ослын тоо



1	Явганаас бэртэх	3321 хүн
2	Хөдөлгөөний инерци, эвгүй хөдөлгөөнөөс үүдэлтэй	3186 хүн
3	Нурж унах, Өндрөөс унах	625 хүн
4	Зам тээврийн осол	625 хүн
5	Мөргөлдөх	438 хүн

Лавлах материал: Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам "2018 оны Хөдөлмөрийн ослын нөхцөл байдлын шинжилгээ: Нийгмийн даатгал, эрүүл ахуй (Нийгмийн халамжийн байгууллага)" 2019 оны 5 сар



"Явганаас бэртэх", "Хөдөлгөөний инерци, эвгүй хөдөлгөөнөөс үүдэлтэй" осол их байна шүү.





Мөн шөнө орой, үйлчлүүлэгч ч нойрмог байдаг тул асрахад өдрийн цагаас илүү хүнд бөгөөд биеэ эвгүй хөдөлгөчих гээд байдаг.



Шөнө байсан ч өвдөлт мэдэрвэл, эргэлзэлгүй мэдэгдээрэй.

Явал нурууны өвчнөөс урьдчилан сэргийлж чадах юм болоо?

Арга янз бүрээрээ л байгаа.

Юуны өмнө, асаргааны зөв мэдлэг, техник эзэмших хэрэгтэй.

Түүнчлэн нь нурууны хамгаалалт, ачаалал бууруулах хэрэгсэл ашиглах нь дээр.

"Явганаас бэртэх" осол жилд 3000-аас илүү хүн өртсөн байна шүү дээ.

Тийм ээ! Ганцаараа төдийгүй

Үйлчлүүлэгчтэй хамт унасан тохиолдол ч бас байдаг.



Аюултай юм аа....!





За тэгэхээр,




Бодит ажлын талбарыг


авч үзэцгээе!

1

# ЖИШЭЭ 1







Та хоёр зүгээр үү!?

Айхтар дуу гарч байх чинь...

Бэртчихээгүй биз...?

Баярлалаа, би зүгээр ээ.

За, ашгүй дээ.



Баяртай...!


Баяртай биш ээ!!

Эмч ээ!



Амь насанд аюулгүй байна.

Нуруу, толгойдоо хөнгөн доргисон байна.



Ёохх, ашгүй дээ

Харин ч ашгүй биш шүү.



2 гар чинь чөлөөгүй байх аюултай биз дээ?

OK!

Асаргааны үед гартаа юм барьж явах ёсгүй.



Шал нойтон байх ч тохиолдолтой учраас.

Дандаа хөл доорхоо харж, анхаарч явах хэрэгтэй.

Корридорыг хамгийн туруунд цэвэрлэе

通路中 特に優先!

Шал норвол дор дор нь сайн цэвэрлэхгүй бол болохгүй.



Дээр нь чи явганаас унах ямар аюултайг мэдэхгүй л байна даа.






Толгойгоо хүчтэй цохивол амь насыг чинь хохироож ч болзошгүй шүү дээ.

Нэг шинжилгээ өгөөрэй.

Дашрамд, ямар нэг хэвийн бус зүйл байсангүй.

# ЖИШЭЭ 2








Харахад худлаа юм шиг ч, биеийн тамир хийдэг хүн шүү, би!


Залуу хүн ямар чадалтайг харж байгаарай!



Тэгж болохгүй ээ. Туслах хэрэгсэл аваад ирье, хүлээж байгаарай.



Ийм үед, сэтгэлийн хатаараа үзнээ!



Заа  
とっ  
とっ  
とっ

Хмм, эмчид тэгж төвөг удаж чадахгүй нь. Ганцаараа хийнээ.




Бодсоноос хүнд юм гээч.




Гайгүй юу?

Ганцаараа хэцүү байх аа...



Ааааа...

Арай... Нуруу өвдөөд байгаа юм байх даа!?







Ганцаараа асаргаа хийх үедээ туслах хэрэгсэл ашиглана. Жишээ нь, шилжүүлэх тавцан байвал...




Нэг талыг нь орон дээр тавиад

Нөгөө талыг нь өгзөг доогуур нь хийвэл



Ийм амархан зөөчихнэ.

Зүгээр үү? Тэсээрэй!



Нурууны цочмог хурц өвдөлт, өөрөөр хэлбэл

"Нуруунд чинь юм орчихсон" байна.



Цаашид, нурууны ачаалал багасгасан байрлалаар өргөхийг сурч аваарай.



Нурууны хамгаалах бүс

Үйлчлүүлэгч том биетэй бол,

Хамгаалах, туслах хэрэгсэл сайн ашиглаарай.



Дараа нь, биеийн байдал муу үед өөрийгөө хүчлэлгүй мэдэгдэх хэрэгтэй!




Бид чинь нэг баг шүү дээ.



Эцэст нь... Дүрмээ баримтлах шүү дээ.

Дотоод дүрмийн ач холбогдлыг өөрийн биеэр амсаж сурлаа.

# ЖИШЭЭ 3





Нөхцөл байдал ямар байна?

Гэнэт бөөлжөөд, ухаан нь орон гаран байна.

Яаралтай тусламж үзүүлсэн.



Чи...



Маск ч үгүй, бээлий ч өмсөхгүйгээр

Арга хэмжээ авчихлаа гэж үү?

Айн, өө уучлаарай. Сандраад...



Яаралтай тусламж үзүүлсэн нь сайн хэрэг ч..



Цус, өтгөн, бөөлжис зэрэгт нүцгэн гараараа шууд хүрч болохгүй гэсэн дүрэмтэй.



Норо вирусээр өвдсөн байх магадлалтай тул шинжилгээ өгөх шаардлагатай ч...

Лавтай зүгээр байх аа.

За, ашгүй дээ



Чи ч гэсэн заавал шижилгээ өгөөрэй.

Халдварт өвчин аюултай шүү дээ.



Бөөлжисэнд шууд хүрэх маш аюултай.

Халдвар авсан ч байж болзошгүй.



Айн, тийм айхтар сүртэй биш байлгүй дээ

Усанд орчихвол зүгээр ээ.

Яасан ойлгодоггүй хүн бэ



Эмчийн хэлсэн зөв байж!


Халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд хамгаалах хэрэгсэл ашиглах дүрэмтэй



Хамгаалах хэрэгсэл ашиглаж дам халдвараас урьдчилан сэргийлнэ.

Нүцгэн гар, энгийн хувцастай арга хэмжээ авч болохгүй

### Мэс заслын маск



Журмаар тогтоогдсон маск хэрэглэх.

### Нэг удаагийн бээлий



Нэг удаа хэрэглээд заавал хаях ёстой.


### Ханцуйтай хормогч



Ханцуйг нь шамлахгүй.

### Цэвэрлэх арга

① Бохирдсон цагаан хэрэглэлийг гялгар уутанд битүүмжилнэ.



② Бохирдсон хэсэгт бактери устгагч шүршинэ.



Бохирдсон цагаан хэрэглэлийг буцалгаж, эсвэл уусмалаар ариутгана.

③ Маск, бээлий, цаас зэргийг заавал тэр дор нь хаяна.



Савангаар гараа угаагаад,

Сайтар ариутгаарай.





Шинжилгээний дараа

Хариу нь коро вирус биш ханиад гэж гарчээ.



Чинийх ч сөрөг гарсан.


Энэ явдлаас ухаарч, дараагийн удаад ижил алдаа гаргахааргүй боллоо.



## Асаргааны ажилд анхаарах зүйлс




**1** | Хоёр гар завгүй байгаа үед анхааралтай байх хэрэгтэй.



Хоёр гар завгүй байдлаас үүдэн явганаас бэртэх зэрэг санаандгүй эрсдэл үүсдэг тул болгоомжлоорой.

**2** | Нойтон болон бохир шалнаас болгоомжтой байгаарай.




Хальтардаггүй гутал өмсөх, 4S(Нийтлэг сурах бичгийг харна уу)-ийн дүрмийг баримталья.

**3** | Биеийн эвгүй байрлалаар асрахаа зогсооё.



Биеийн эвгүй, хүчилсэн байрлалаар асарч сувилах нь нурууны гэмтлийн үүсвэр болдог.

**4** | Халдварт өвчнөөс сэргийлье.



Бөөлжис зэрэг ялгадаст нүцгэн гараараа хүрч болохгүй.

Хөдөлмөрийн осол гэдэг чамд, надад хамаагүй асуудал огт биш. Бид бүгдийн асуудал юм.



Дүрэм журмаа дагаж мөрдсөнөөр "бие махбод", "гэр бүл", "амьдрал"-аа хамгаалж байгаа гэдгийг байнга санаж яваарай.

Ямар нэг зүйл тохиолдох үеэ бодолцон

Ердийн үед ч ажлынхантайгаа найрсаг харилцаатай байх нь чухал.



За


Аюулгүй байдал, эрүүл ахуйдаа анхаарч, өдөр бүр сайн ажиллана аа.




Аанхан

## Асаргааны ажил

### Үүнийг ч бас анхааръя! Аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөмж




**1** | Усанд оруулж байхдаа битүү халуунд цохиулах



Халуун усны өрөө халуун бас чийгтэй байдаг тул асрагч нар халуунд цохиулах тохиолдол ихэсч байна (Нийтлэг сурах бичгийг харна уу).

**2** | Бэрхшээл тулгарвал зөвлөөрэй.



Ямар нэг бэрхшээлтэй зүйл тулгарвал ганцаараа зовниод байлгүй эргэн тойрныхонтойгоо болон мэргэжлийн эмчтэй зөвлөлдөөрэй.

**3** | Шөнийн ээлжнээс буусны дараа сайн унтаж амрах.



Ядаргаа нь хөдөлмөрийн ослын гол суурь болдог. Шөнийн ээлжнээс буусныхаа дараа нарны гэрэл хаасан газар сайтар унтаж амраарай.


**4** | Сунгалтын дасгалаар нурууны гэмтлээс урдчилан сэргийлье.



Сунгалтын дасгалаар биеийн хөшингийг арилгаж, нурууны өвчнөөс урдчилан сэргийлцгээе (Нийтлэг сурах бичгийг харна уу).

Ажил дунд нуугдаж буй аюулыг мэдэж авцгаая.  
**Аюулаас урьдчилан сэргийлэх сургалт (КҮТ)**

**Q** Ямар газар аюултайг бодож үзэцгээе!



**A** Энэ аюулын тэмдэг!




**1**

Бохирдол ба бөөлжисийг нүцгэн гараар цэвэрлэхгүй.



**2**

Шалан дээр юм унаж замбараагүй байвал аюултай.



**3**

Өөрийгөө хүчлэн ганцаараа асарч сувилах хэрэггүй.



**Өөр ямар аюулын тэмдэг байгааг бодож үзэцгээе.**

Комикоор танилцах

## Асаргааны ажлын аюулгүй байдал, эрүүл ахуй

2020 оны 3 сарын хэвлэл

Эрхлэн гаргасан: Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төлөвлөсөн: Mizuho Information & Research Institute, Inc.

Хянан тохиолдуулсан: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын материал бэлтгэх комисс  
Асаргааны салбарт хамаарах аюулгүй ажиллагааны сургалтын материал бэлтгэх ажил

Боловсруулсан: Sideranch Inc.





Тус материалын талаарх лавлагаа

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны  
Хөдөлмөрийн стандартын хороо, Аюулгүй байдал, эрүүл  
ахуйн газар, Аюулгүй байдлын хэлтэс